



2022.11.22.

008/01

Улаанбаатар хот

Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д

Эрэнцав ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн тайлан хүргүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчилэн баталсан “Компанийн засаглалын кодекс” болон Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ны өдрийн А/58 тоот тушаалаар баталсан “Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал”-ын дагуу Эрэнцав ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг боловсруулсан болно.

Энэхүү кодекс нь компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах, байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоож хэрэгжүүлэх тогтолцоо юм. Хувьцаа эзэмшигчид, бусад оролцогчид нь компанийн зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрдсэн эсэхэд ТУЗ болон хөндлөнгийн аудитаар дамжуулан хяналт тавьдаг. Компанийн засаглалын сайн туршлагыг хэрэгжүүлснээр компанийн үнэлгээ өсөх, өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд түлхэц өгөхүйц ач холбогдолтой юм.

Эрэнцав ХК-ийн хувьд 2019-2022 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс орны эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа удааширч саарсан хэдий ч, тулгарсан хүндрэл бэрхшээлийг даван туулж, 2022 оны 4-р улиралд компанийн засаглалын болоод эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор тодорхой шинэчлэлт, өөрчлөлтүүдийг хийгээд ажиллаж байна. Үүнд:

- Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022.09.12-ны өдрийн А/99 тоот тушаалаар “Эрэнцав” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд сэргээн бүртгүүлсэн.
- Компанийн нийт Хувьцаа эзэмшигчдийн 2022.09.28-ны өдрийн ээлжит бус хурлын 01-р тогтоолоор компанийн 2021 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг хэлэлцэн баталсан;
- 2022.09.28-ны өдрийн ХЭХ-ын 02-р тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хараат бус гишүүдийг шинээр томилсон бөгөөд Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.4-т заасны дагуу ТУЗ-н гишүүдийн 1/3-ийг хараат бус гишүүнээр бүрдүүлсэн.
- 2022.10.15-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 01-р тогтоолоор ТУЗ-н даргыг, 02-р тогтоолоор Гүйцэтгэх захирлыг, 03-р тогтоолоор ТУЗ-н нарийн бичгийн даргыг тус тус томилоод байна.
- Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-т заасны дагуу 2022.10.15-ны өдрийн ТУЗ-н хурлын 04-р тогтоолоор ТУЗ-н дэргэдэх Аудитын, Цалин, урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулж хороодын гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээс бүрдүүлсэн.
- 2022.11.11-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 06-р тогтоолоор ТУЗ-н дэргэд ажиллах Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, хорооны гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр бүрдүүлээд байна.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх нь компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг

боловсруулан мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулах үйл ажиллагаа бөгөөд бид уг үнэлгээний гол үзүүлэлтүүд болох

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт;
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг;
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал;
4. Аудит, хяналтын тогтолцоо;
5. Эрсдэлийн удирдлага;
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал;
7. Оролцогч талуудын эрх ашиг;
8. Компанийн соёл;
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх;

зэрэг үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшүүлж, мөрдөн ажиллах зорилгоор 2022.11.11-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 05-р тогтоолоор дараах Дүрэм, Журам, Бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн батлаад, хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Компанийн ТУЗ-н үйл ажиллагааны журам;
2. Компанийн ТУЗ-ын Хороодын үйл ажиллагааны журам;
3. Аудитын хорооны үйл ажиллагааны журам;
4. Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам;
5. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам;
6. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам;
7. Компанийн ёс зүйн дүрэм;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдийн болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар баримтлах бодлого;
9. Компанийн Залгамж халааны бодлогын баримт бичиг;
10. Аудитын бодлогын баримт бичиг;
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам;
12. Дотоод хяналтын журам;
13. Санхүүгийн үйл ажиллагааны журам;
14. Ногдол ашгийн журам;
15. Мэдээллийн үйл ажиллагааны журам;
16. Комплайнсын хяналтн заавар;
17. Оролцогч талуудтай харилцах Бодлогын баримт бичиг;

зэрэг болно.

Эрэнцав ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь “Компанийн засаглалын кодекс”-ийн биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавин ажилладаг бөгөөд компанийн засаглалын зарчмуудын бүхий л заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллахын сацуу Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ын хурлуудаар батлагдсан компанийн засаглалын удирдлагын баримт бичгүүдийг Хөрөнгийн биржийн цахим хуудас болоод Эрэнцав ХК-ийн цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулан олон нийтэд хүргэж, мэдээлэн ажиллаж байна.

Жич: Компанийн засаглалын кодекс-ийн хэрэгжилтийн тайланг цахим шуудангаар илгээсэн.

**Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга:**

Ц.Лхагвадорж

**ЭРЭЭНЦАВ” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАН БАТАЛГААЖИЛТ**

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна				
№	Зүйл	Хэрэгжилт	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 76-р зүйлийн 76.1-д заасны дагуу ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05 тоот тогтоолын 1-р хавсралтаар ТУЗ-н үйл ажиллагааны журмыг баталж, ТУЗ-н дарга, гишүүд, НБД-ын ажлын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зааж өгсөн. Мөн ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-01 тоот тогтоолоор ТУЗ-н дарга, А-03 тоот тогтоолоор ТУЗ-н НБД нар тус тус томилогдон ажиллаж байна.	2	
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-р заалтын хүрээнд ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн хурлын А-05 тоот тогтоолын 5-р хавсралтаар Нэр дэвшүүлэх журам-г , 9-р хавсралтаар Залгамж халааны бодлогын баримт бичиг-г тус тус баталсан.	2	
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилла сан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсанд байршуулна.	ТУЗ-н гишүүдийн холбогдох мэдээллүүдийг Хөрөнгийн биржийн цахим хуудас болоод компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav/ -нд нээлттэй, ил тод байршуулж, өөрчлөлт орсон тухай бүрт шинэчилдэг ба үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусган ажиллаж байна. 2022 оны 4-р улиралд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн болоод ТУЗ-н хурлуудын шийдвэрийн дагуу шинээр томилогдсон гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд тусгаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.	0	
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Компанийн тухай хуулийн 75.1, 81.1-р заалтуудын хүрээнд ТУЗ-н дэргэдэх Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодыг ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоолоор, ТУЗ-н үйл ажиллагааны журмыг ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05 тогтоолын 2-р хавсралтаар тус тус баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Холбогдох тогтоолуудыг энэхүү тайлангийн хавсралтаар хүргүүлсэн.	2	
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг сургалтад тогтмол хамруулна.	Хувьцаа эзэмшигчдийн 2022.09.28-ны өдрийн хурлын 02-р тогтоолын хүрээнд ТУЗ-н гишүүдийг Компанийн засаглалын сургалтанд хамруулах үүрэг өгөгдсөн бөгөөд сургалтын хуваарьт хугацаа болохыг гишүүд хүлээж байна.	1	
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Компанийн тухай хуулийн 82-р зүйлийн 82.1-д заасны дагуу 2022.10.15-ны өдрийн ТУЗ-н А-03 тоот тогтоолоор ТУЗ-н Нарийн бичгийн дарга томилогдож, эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	
ДҮН			9	
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.				
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.4-н дагуу ТУЗ-н гишүүдийн 1/3-д хараат бус гишүүд сонгогдон ажиллаж байна.	2	
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна.	ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоолоор ТУЗ-н дэргэдэх Аудитын хороог байгуулж, хорооны гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр бүрдүүлсэн. Хорооны бүрэлдэхүүнд ТУЗ-н дарга ороогүй болно.	2	

	Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг ТУЗ-н 2022.11.11-ны өдрийн А-05 тоот тогтоолын 3-р хавсралтаар, Эрээнцав ХК-н Аудитын Бодлогын баримт бичгийг ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05-р тогтоолын 10-р хавсралтаар тус тус баталсан.		
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Компанийн тухай хуулийн 81.2-д заасны дагуу ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоолоор Цалин урамшууллын хороог байгуулж, хорооны гишүүдийн 1/3-ыг хараат бус гишүүдээр бүрдүүлсэн. Хорооны бүрэлдэхүүнд ТУЗ-н дарга ороогүй, хорооны даргаар хараат бус гишүүн ажиллаж байна. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг ТУЗ-н 2022.11.11-ны өдрийн А-05 тоот тогтоолын 4-р хавсралтаар баталсан.	2	
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Компанийн тухай хуулийн 81.2-д заасны дагуу ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоолоор ТУЗ-н дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог байгуулж, хорооны гишүүдийн 1/3-ыг хараат бус гишүүдээр бүрдүүлж, хорооны даргаар хараат бус гишүүн ажиллаж байна. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг ТУЗ-н 2022.11.11-ны өдрийн А-05 тоот тогтоолын 5-р хавсралтаар, Эрээнцав ХК-н Залгамж халааны Бодлогын баримт бичгийг ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05-р тогтоолын 9-р хавсралтаар тус тус баталсан.	2	
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Компаний тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-д заасны дагуу ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн 06-р тогтоолоор Эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-н дэргэд байгуулж, 05-р тогтоолын 6-р хавсралтаар Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журмыг баталсан.	2	
ДҮН			10	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.				
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Компанийн мэдээллүүдийг Хөрөнгийн биржийн цахим хуудас болоод компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav /-нд нээлттэй, ил тод байршуулж, тогтмол шинэчилэн ажиллаж байна. Эрээнцав ХК-н Мэдээллийн үйл ажиллагааны журмыг ТУЗ-н 2012.09.08-ны өдрийн ээлжит бус хурлын 04-р тогтоолоор баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Компанийн засаглалын баримт бичиг бичгүүд болох нийт 15-н Дүрэм, Журам, Бодлогын баримт бичгүүдийг компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav / болоод Хөрөнгийн биржийн цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулж олон нийтэд түгээж байна. Үүнд: Компанийн ТУЗ-н үйл ажиллагааны журам; Компанийн ТУЗ-ын Хороодын үйл ажиллагааны журам; Аудитын хорооны журам; Цалин, урамшууллын хорооны журам; Нэр дэвшүүлэх хорооны журам; Эрсдэлийн хорооны журам; Компанийн ёс зүйн дүрэм; НСЭБСЗХ-н талаар баримтлах бодлого; Компанийн Залгамж халааны бодлогын баримт бичиг; Аудитын бодлогын баримт бичиг; Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам; Дотоод хяналтын журам; Санхүүгийн үйл ажиллагааны журам; Ногдол ашгийн журам; Мэдээллийн үйл ажиллагааны журам;	2	
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус	Компанийн Үйл ажиллагааны болон Санхүүгийн үйл ажиллагааны тайлан, Хөндлөнгийн аудитын тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тогтмол	1	

	тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	татаж оруулан, тайлагнаж ирсэн. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл, цаг агаарын таагүй нөхцлүүд зэргээс шалтгаалан компанийн засаглалын удирдлага, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьчилан сэргийлэх зорилгоор ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-06 тоот тогтоолоор Компанийн Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, А-05 тоот тогтоолын 6-р хавсралтаар Эрсдэлийн хорооны үйл ажилл агааны журмыг баталсан. Шинээр томилогдсон хорооны гишүүд Компанийн эрсдэлийн удирдлагын тайланг боловсруулах шатанд байна. Түүнчлэн 2022 оны “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн энэхүү тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлж, жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд тусган ажиллаж байна.		
ДҮН			5	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО				
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.				
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-н дэргэдэх Аудитын хороог ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоолоор, Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг 2022.11.11-ний өдрийн А-05 тогтоолын 3-р хавсралтаар, Аудитын Бодлогын баримт бичгийг А-5 тогтоолын 10-р хавсралтаар тус тус баталсан. Эдгээр баримт бичгүүдэд аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, аудиторын эрх үүрэг, хөндлөнгийн аудитортой харилцах зэрэг асуудлуудыг тодорхой тусгаж өгсөн.	2	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	ТУЗ-н 2012.09.08-ны 01 тоот тогтоолоор батлагдсан Эрэнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмын 6.7, 2022.11.11-ны өдрийн А-05 тоот тогтоолоор батлагдсан Аудитын Бодлогын баримт бичгийн 1.2, 9.1-р заалтуудад Хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудитор оролцох асуудлыг зохицуулж өгсөн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудад хөндлөнгийн аудиторыг оролцуулах тухай журмыг мөрдөн ажиллаж байна.	1	
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	ТУЗ-н дэргэдэх Аудитын хороог ТУЗ-н 2022.10.15-ны өдрийн А-04 тоот тогтоол оор, Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг 2022.11.11-ний өдрийн А-05 тогтоолын 3-р хавсралтаар, Аудитын Бодлогын баримт бичгийг А-5 тогтоолын 10-р хавсралтаар тус тус баталсны дагуу мөрдлөг болгон ажиллаж байна. Аудитын бодлогын баримт бичигт дотоод аудитын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт болоод аудитын үйл ажиллагаагай холбоотой нийт чиг үүргүүдийг дэлгэрэнгүй тусган, албажуулж өгсөн. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, бусад тайлангуудыг Хөрөнгийн биржийн цахим хуудас болоод компан ийн цахим хуудас / https://EREENCAV.wixsite.com/ereentsav/shareholders /-нд тогтмол оруулан, олон нийтэд мэдээлж байна. Компанийн цахим хуудсанд Shareholders /хувьцаа эзэмшигчид/ гэсэн Хуудас шинээр нээж Аудитын БББ, Аудитын хорооны дүрэм болон бусад дүрэм журмуудыг оруулж өгсөн. https://ereentsav.wixsite.com/ereentsav/shareholders	2	
ДҮН			5	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА				
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.				

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Компаний тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-д заасны дагуу ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн 06-р тогтоолоор Эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-н дэргэд байгуулж, 05-р тогтоолын 6-р хавсралтаар Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журмыг баталсан. Журмын 3-р бүлэгт компанийн эрсдэлийн удирдлагын бүтцийг , 4-р бүлэгт эрсдэлийн удирдлагын зааврыг тус тус тусгаж албажуулсан. Түүнчлэн ТУЗ-н 06-р тогтоолын 2-р зүйлд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг ТУЗ-д тогтмол тайлагнаж ажиллахыг хорооны даргад даалгасан.	2	
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Компаний тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-д заасны дагуу ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн 06-р тогтоолоор Эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-н дэргэд 3-н гишүүн /үүнээс 2 нь хараат бус гишүүн/-ий бүрэлдэхүүнтэй байгуулсан. Шинээр батлагдсан тогтоолууд болон хорооны үйл ажиллагааны журмыг компанийн үйл ажиллагааны жилийн эцсийн тайланд дэлгэрэнгүй тусгах болно. 2022.11.11-ний өдрийн 05-р тогтоолын 6-р хавсралтаар Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журмыг баталсан ба компанийн цахим хуудас https://EREENTSAV.wixsite.com/ereentsav/ - аар дамжуулж олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	2	
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл, цаг агаарын таагүй нөхцлүүд зэргээс шалтгаалан компанийн засаглалын удирдлага, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьчилан сэргийлэх зорилгоор ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-06 тоот тогтоолоор Компанийн Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, А-05 тоот тогтоолын 6-р хавсралтаар Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журмыг баталсан. Шинээр томилогдсон хорооны гишүүд Компанийн эрсдэлийн удирдлагын тайланг болов сруулж байгаа бөгөөд уг тайлан эцэслэн батлагдсаны дараа компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд ил тод, нээлттэй нийтэд мэдээлнэ.	0	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	2022.11.11-ний өдрийн ТУЗ-н хурлын А-05 тоот тогтоолын 16-р хавсралтаар Эрэнцав хувьцаат компанийн Комплайнсын хяналтын заавар -г баталсан. Уг зааварт компанийн комплайнсын хяналтын бүтэц, хараат бус байдал, хяналт хэрэгжүүлэх зарчмууд, комплайнсын хяналтын ажилтан /нэгж/-ы эрх үүргийг тодорхой тусгаж өгсөн. Комплайнсын хяналтын ажлын хараат бус байдал, үр дүнд ТУЗ хяналт тавьж ажиллах тухай 4.2.6-д заасан.	2	
ДҮН			6	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.				
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012.09.08-ны өдрийн 02 тоот шийдвэрээр баталсан ТУЗ-ын үйл ажиллагааны журмын 11.1-р зүйлд “ТУЗ-н гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг Цалин, урамшууллын хорооны саналыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно” гэж албажуулсныг мөрдлөг болгон ажиллаж байна. Түүнчлэн Компанийн Комплайнсын хяналтын зааврын 5.1, 5.2-т ТУЗ-н гишүүдийн цалин урамшууллыг ХЭХ-аар хэлэлцүүлж батлахыг албажуулсан. Оролцогч талуудтай харилцах бодлогын баримт бичгийн 6-р бүлгийн Цалин хөлс, урамшуулалын хэсэгт цалин хөлс, урамшуулал олгох шалгуур үзүүлэлтүүд, хувь хэмжээг тодорхой тусгаж баталсан. ТУЗ-н үйл ажиллагааны журам, Комплайнсын хяналтын заавар, Оролцогч талуудтай харилцах бодлогын баримт бичгийг энэхүү тайлангын хавсралтаар илгээсэн.	1	

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Компанийн Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг Цалин урамшууллын хорооны саналыг үндэслэн ТУЗ-өөс тогтоох, компаний ажилтнуудын цалингийн сүлжээний схемийг Гүйцэтгэх захирал баталж, хэрэгжүүлэхийг Комплайнсын хяналтын зааврын 5-р бүлгийн 5.3-т тодорхойлон баталсан. Цалин урамшууллын нэгдсэн схемийг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шинэчилэн батлахаар төлөвлөөд ажиллаж байна.	1	
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс орны эдийн засгийн хүндрэл зэргээс шалгаалан 2019-2022 онуудад компанийн үйл ажиллагаа доголдож, бизнесийн ашиг орлогогүй ажилласан. Иймээс компанийн зүгээс аливаа нэг гүйцэтгэх удирдлагад үндсэн цалин, шагнал, урамшуулал олгоогүй бөгөөд холбогдох асуудлуудыг компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангуудад тодорхой тусган ажиллаж байна.	0	
ДҮН			2	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ				
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ				
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	2022.11.11-ны өдрийн ТУЗ-н А-05 тогтоолын 17-р хавсралтаар Оролцогч талуудтай харилцах бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд компанийн зүгээс бүх талын гадна, дотор оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, ажиллагчид, төрийн болон төрийн бус байгууллагууд, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, санхүүжүүлэгчидтэй харилцах хүрээг зохицуулахаар заасан.	2	
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Компанийн үйл ажиллагааны тайланд хэлэлцэж баталсан Оролцогч талуудтай харилцах бодлогын баримт бичгийг хэрхэн хэрэгжүүлж ажиллаж байгаа тухай тодорхой тусган ажиллаж байна.	0	
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	ТУЗ-н тогтоолоор баталсан Оролцогч талуудтай харилцах бодлогын баримт бичиг болоод холбогдох мэдээллүүдийг компанийн цахим хуудсанд дээр /https://EREENTSAV.wixsite.com/ereentsav/ байршуулж, олон нийтэд танилцуулах зарчмыг барин ажиллаж байна.	2	
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	ТУЗ-н 2022.11.11-ны өдрийн А-05 тоот тогтоолын 17-р хавсралтаар баталсан Оролцогч талуудтай харилцах Бодлогын баримт бичгийн 3.11, 4.9-д компанийн ажилтнууд санал, хүсэлт, гомдол гаргах, компанийн удирдах албан тушаалтнууд ажилтны санал, хэсэлт, гомдлыг хүлээн авч хууль, журмын хүрээнд шийдвэрлэж байх зарчмыг баталсан.	2	
ДҮН			6	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ				
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.				
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05 тоот тогтоолын 7-р хавсралтаар Компанийн Ёс зүйн дүрэм –ийг баталж, албан хаагчдын албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоож өгсөн. Уг дүрмийг компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан.	2	
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн тогтоолоор баталсан Ёс зүйн дүрмийн 5-р бүлэгт ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэхэд баримтлах зарчмыг, 4-р бүлэгт ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхойлон оруулсан.	2	

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн тогтоолоор баталсан Ёс зүйн дүрмийн 2.1.2-д Шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхолын зөрчлөөс ангид байна, 2.1.6-д Албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн ман, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна гэж заасан.	2	
ДҮН			6	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.				
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav / болон Хөрөнгийн биржийн цахим хуудсанд компанийн үйл ажиллагааны, санхүүгийн, хөндлөнгийн аудитын тайлангуудыг нээлттэй байршуулсан. Компанийн засаглалын бүтэц, зохион байгуулалтын схемийг Компанийн дүрэм болон холбогдох журмуудад тусгасны дагуу компанийн цахим хуудсанд мэдээлэн ажиллаж байна.	2	
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	ТУЗ-н 2012.09.08-ны өдрийн 04-р тогтоолоор Мэдээллийн үйл ажиллагааны журмыг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav /-нд компанийн мэдээллүүдийг нээлттэй, ил тод нийтэлж, сошиал сүлжээний Facebook, Twitter хуудсууд, чат группээр харилцан мэдээлэл солилцон, ажиллаж байна.	2	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хувьцаа эзэмшигчдийн санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг эрхийг хангах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээллийг тухай бүр сонин хэвл элд нийтлүүлж ирсэн. Мөн хаяг, утасны дугаар нь тодорхой бус хувьцаа эзэмшигчдийг тодруулах зорилгоор 2022.11.03-ны өдрийн 007/01 тоот албан бичгийг Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлэн ажиллаж байна.	2	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		2	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 81-р зүйлийн 81.1-ийн дагуу ТУЗ-н 2022.11.11-ний өдрийн А-05 тоот тогтоолын 8-р хавсралтаар Нэгдмэл сонирхолтой этгээдийн болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар баримлах бодлогыг баталж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх зорилгоор компанийн цахим хуудас / https://EREENTSAV.wixsite.com/ereentsav / - нд нийтэлсэн болно.	2	
ДҮН			10	
НЭГДСЭН ДҮН			70	97%